

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

БАТЛАВ:
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ Н.УДААНЖАРГАЛ /

БАТЛАВ:
“ДАМЭН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

/ Б.НОМИНЗУЛ /

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022 оны 09 сарын
22-ны өдөр

№ ТТЗ-МН 22/08

Улаанбаатар
хот

Энэхүү худалдах, худалдан авах гэрээг нэг талаас “Тавантолгой төмөр зам” ХХК /цаашид “Худалдан авагч” гэх/, түүнийг төлөөлж Захиргаа удирдлагын газрын дарга Я.Намсрай, нөгөө талаас “Дамэн” ХХК /цаашид “Худалдагч” гэх/, түүнийг төлөөлж Захирал Б.Номинзул нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлүүдийг үндэслэн дараах нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Гэрээгээр Худалдагч нь гэрээний Хавсралт №1-д заасан биет байдлын болон эрхийн доголдолгүй Хөдөлмөр хамгааллын өвлийн **380 ширхэг** 6 хос ажлын хувцас /цаашид “Бараа” гэх /-ыг холбогдох баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, Худалдан авагч нь Барааг шалган хүлээн авч, төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Барааны нийт үнэ: 147,972,000 /Нэг зуун дөчин долоон сая есөн зуун далан хоёр мянган/ төгрөг.
- 1.3. Энэхүү зүйлийн 1.2-д заасан үнэд НӨАТ болон бусад татвар, хураамж, хүргэлтийн хөлс багтсан болно.
- 1.4. Талуудын аль нэг нь хуулийн этгээдийн хувьд өөрчлөн байгуулагдсан нь энэхүү гэрээг цуцлах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.
- 1.5. Талууд харилцан тохиролцсоноор энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд аливаа нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулна.
- 1.6. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй.

1.2 Гэрээний хавсралтууд:

Дараах бичиг баримтуудыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

- 1.2.1 Худалдан авах барааны техникийн тодорхойлолт / Хавсралт №1/

1.2.2 Бараа бүтээгдэхүүний нэгжийн болон нийт үнэ /Хавсралт №2/

1.2.3 Бараа бүтээгдэхүүний размерийн задаргаа /Хавсралт №3/

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Худалдагч нь Барааг энэхүү гэрээг баталгаажиж урьдчилгаа төлбөр шилжсэн өдрөөс хойш эхний нийлүүлэх хугацаа хуанлийн 10 хоног, эцсийн хугацаа хуанлийн 25 хоногт багтаан Худалдан авагчийн агуулахад хүргэн өгч нийлүүлнэ.

Гурав. Барааны чанар

3.1. Худалдагчийн нийлүүлэх Бараа нь Монгол Улсын чанарын стандартын шаардлагыг хангасан, Худалдан авагчид урьдчилан ирүүлсэн сертификат, чанарын гэрчилгээнд нийцсэн байна.

3.2. Худалдан авагч гэрээний дагуу нийлүүлсэн Барааг шалгаж авна. Нийлүүлсэн Барааг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлын талаар Худалдагчид доголдол илэрсэн өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

3.3. Барааны чанарын баталгааны хугацаа нь 12 сар байна.

Дөрөв. Төлбөрийн нөхцөл

4.1 Урьдчилгаа төлбөр 70 хувийг гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор, үлдэгдэл төлбөр 30 хувийг Бараа нийлүүлсний дараа худалдагчийн Хаан банкны төгрөгийн 5721132341 дансанд нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.

Тав. Худалдагчийн эрх, үүрэг

5.1 Энэхүү гэрээний дагуу Худалдагч нь дараах эрхтэй байна:

5.1.1 Эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй Барааг тогтоосон хугацаанд хүлээн авахыг Худалдан авагчаас шаардах;

5.1.2 Нийлүүлсэн барааны үнийг тогтоосон хугацаанд төлөхийг шаардах.

5.2 Энэхүү гэрээний дагуу Худалдагч нь дараах үүрэгтэй байна:

5.2.1. Худалдан авагчийн захиалсан Барааг хугацаанд нь нийлүүлэх;

5.2.2 Барааг тээврийн хэрэгсэлд ачихаас ажлын 3 хоногийн өмнө энэ талаар албан бичиг, телефакс, утас, email, захидлаар Худалдан авагчид мэдэгдэх;

5.2.3 Худалдан авагчийн шаардлагаар эрхийн зөрчилтэй, биет байдлын доголдолтой барааг буцаан авч шаардлага хангасан шинэ бараагаар шуурхай сольж өгөх;

5.2.4 Барааг өөрийн зардлаар нийлүүлэлтийн цэгт хүргэж өгөх;

5.2.5 Худалдан авагчийг барааны чанар, материал, стандартын талаар үнэн зөв мэдээллээр хангах;

5.2.6. Энэхүү гэрээг байгуулах явцад олж мэдсэн, Худалдан авагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар бусдад задруулахгүй байх, гэрээнд зааснаас өөрөөр ашиглахгүй байх.

5.2.7. Гэрээний 2.1-т заасан хугацаанд Барааг нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд нийт үнийн дүнгийн 0,3 хувийн алдангийг худалдан авагчид төлөх.

Зургаа. Худалдан авагчийн эрх, үүрэг

6.1 Энэхүү гэрээний дагуу Худалдан авагч нь дараах эрхтэй байна:

6.1.1 Захиалсан барааны доголдлыг арилгуулах буюу доголдолгүй ижил төрлийн бараагаар солиулах, доголдлыг арилгахад гарсан зардлаа төлүүлэх эсхүл гэрээг цуцлах тухай шаардлага гаргах;

6.1.2 Гэрээнд заасан хугацаанд Барааг нийлүүлэхийг Худалдагчаас шаардах;

6.1.3 Барааг хүлээлцэхэд чанар, стандартын шаардлага хангахааргүй байвал хүлээж авахаас татгалзах.

6.2 Энэхүү гэрээний дагуу Худалдан авагч нь дараах үүрэгтэй байна:

6.2.1. Худалдагчаас Барааг нийлүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор барааг хүлээж авах бэлтгэлийг хангах;

6.2.2 Барааг хүлээж авахдаа тоо, чанар, иж бүрдлийг шалгаж, акт үйлдэж зохих бичиг баримтыг бүрдүүлэх;

6.2.3 Гэрээний 1.2.3.-т заасан хуваарийн дагуу төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд нийт үнийн дүнгийн 0,3 хувийн алдангийг Худалдагчид төлөх.

Долоо. Эрсдэл шилжих

7.1. Барааг Худалдан авагчид хүлээлгэн өгснөөр бараа устаж, гэмтэхээс үүсэх эрсдэл Худалдан авагчид шилжинэ.

7.2. Худалдан авагч Барааг хүлээн авах акт үйлдсэнээр хүлээн авсанд тооцно.

Найм. Талуудын хариуцлага

8.1. Барааны эдэлгээний баталгаат хугацаа 12 сар байна. Эдэлгээний хугацаанаас өмнө материалын чанараас хамаарч ажлын хувцас урагдаж шаардлага хангахгүй болсон тохиолдолд Худалдан авагч нь энэ талаар Худалдагчид мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш хуанлийн 14 хоногийн дотор Худалдагч нь урагдсан барааг шинээр сольж өгнө.

8.2. Худалдагчийн буруугаас биет байдлын болон эрхийн доголдолтой Бараа нийлүүлсэн бол Худалдагч нь уг доголдлыг өөрийн зардлаар арилгана.

8.3. Энэхүү гэрээний нөхцөлийг зөрчсөнөөс аль нэг талд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгана. Хохирол учирсан эсэхийг хохирогч тал нотолно.

8.4 Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд гэрээнд заасан үнээр төлбөр хийгдэнэ. Хэрэв үнэ өөрчлөгдөх бол энэ талаар Худалдагч нь Худалдан авагчид 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Ес. Давагдашгүй хүчин зүйл



9.1. Энэхүү гэрээг байгуулсны дараа давагдашгүй хүчин зүйл (тухайлбал, үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэний үймээн, ажил хаялт, Засгийн газрын шийдвэр гэх мэт)-ийн үйл явдлын шууд эсхүл шууд бус үйлчлэлийн улмаас аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийн хугацааг тухайн нөхцөл байдал арилгах хүртэл хойшлуулж болно.

9.2. Үүрэг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн эсхүл дууссан талаар талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

9.3 Давагдашгүй хүчин зүйлийн үйл явдал болсон эсэхийг эрх бүхий байгууллага нотолно.

Арав. Маргааныг шийдвэрлэх

10.1. Энэхүү гэрээтэй холбогдон үүсэх маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

10.2. Маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй бол тухайн маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван нэг. Гэрээний үйлчлэх хугацаа

11.1. Энэхүү гэрээ нь 1 жилийн хугацаанд мөрдөгдөх бөгөөд гэрээг дүгнэж акт үйлдэн тооцоо нийлснээр дуусгавар болно.

11.2. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцон сунгаж болно.

11.3. Энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно. Үүнд:

11.3.1. Гэрээгээр тогтоосон хугацаанд Худалдан авагч төлбөрөө төлөөгүй, түүнчлэн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нийлүүлэлт хийх боломжгүй болсон тухай Худалдан авагчид албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд Худалдагчийн санаачлагчаар;

11.3.2. Худалдан авагч барааг үргэлжлүүлэн худалдан авахаас татгалзсан тухай Худалдагчид албан ёсоор бичгээр мэдэгдэж тооцоо нийлж, нийлүүлсэн Барааны төлбөрөө бүрэн төлж барагдуулсан, гэрээнд заасан хугацаанд хавсралтад заасан Барааг нийлүүлээгүй тохиолдолд Худалдан авагчийн санаачилгаар;

11.3.3. Худалдагч нь чанар стандартын шаардлага хангаагүй Бараа нийлүүлсэн тохиолдолд Худалдан авагчийн санаачилгаар;

11.3.4. Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр;

11.3.5. Давагдашгүй хүчин зүйлийн үйл явдал болсны улмаас.

Арван хоёр. Бусад зүйл

12.1. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

12.2. Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй бусад асуудлын хувьд Монгол Улсын Иргэний хууль мөрдөгдөнө.

12.3. Энэхүү гэрээнд талуудын зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

12.4 Энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан Талууд мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг төлбөрийг харилцан төлөөгүй болохыг үүгээр баталж байна.

12.6 Энэхүү гэрээний дараах хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болно:

12.6.1. Худалдагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

12.6.2. Худалдан авагчийн ирүүлсэн үнийн санал

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ



“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн
Захиргаа, удирдлагын газрын дарга
Я.Намсрай

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Нарны зам-62, Юнион Бюлдинг
В корпус 11 давхар,
Утас: 7777-7727

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ



“Дамэн” ХХК-ийн ерөнхий нябо
УОН9474 2654296
С.Долзолмаа

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол
дүүрэг, 2-р хороо 2-р хороолол, 69-15
тоот

Утас 99914653



ӨВЛИЙН АЖЛЫН ХУВЦАСНЫ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ2022 оны 09 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

1. Ерөнхий шаардлага:

Уг барааг нийлүүлэх компани нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:


- 1.1 Тендерт оролцогч нь гэрээ байгуулагдсан даруй 42,44,46,48,50,52,54,56,58
размеруудаас 1 ком загвар ирүүлж, өмсгөлийг тааруулж үзэх боломжтой
байна. Энэхүү хэмжээгээр хувцасны размер хэмжээг тодорхойлсны үндсэн
дээр захиалгыг гүйцэтгэнэ.
- 1.2 MNS ISO 13688:2000 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй.
Хамгаалалтын хувцас- Ерөнхий шаардлага стандарт"-ын шаардлага хангасан
байна.
- 1.3 Тендерт оролцогч нь тендерийн материал хүлээн авах хугацаанд техникийн
тодорхойлолтод дурдсан бараа тус бүрээс авчирч өгнө.
- 1.4 Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэх хувцасны
дээжийг 4 хосыг авчирч өгнө.
- 1.5 Тендерт оролцогч нь өөрийн нэр бүхий шошгыг унахааргүй оёж бэхэлсэн
байна.
- 1.6 Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид анх
ирүүлсэн 1 ком загварын хувцаснаас материал, чанар, гараар мэдэрхэд
ялгаагүй, өнгө хийцийн хувьд ялгаагүй, өнгө зөрүүгүй адил байна.
- 1.7 Ялгаа гарсан тохиолдолд захиалагч ирүүлсэн хувцсыг бүгдийг гүйцэтгэгчид
бөөнөөр буцааж, тендерийн бичиг баримтад заасан, шаардлага хангасан
хувцсаар солиулна.
- 1.8 Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэг
гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
- 1.9 Бүх хувцас хэрэгслийг хийсэн, эсхүл түүнд орсон материал бүр нь хүний биед
сөрөг нөлөөгүй, аливаад зочрол шархлаа үүсгэхээргүй, биеийн хөлстэй урвалд
орохгүй, зориулалтын хувцасны материалаар хийгдсэн байна. Үүнийг нотлох
шинжилгээний дүгнэлттэй байна.
- 1.10 Угаалга цэвэрлэгээний дараа агшиж сунахгүй буюу, өмсгөлийн анхны
хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байх сайн чанарын материалаар
хийгдсэн байна.(Угаалтаар агшиж сунасан тохилдолд ажлын хувцсыг бүгдийг
солино)
- 1.11 Ажлын хувцсанд угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ,
үйлдвэрлэгчийн нэр, арчилгааны заавар болон бусад шаардлагатай
мэдээллийг хувцас тус бүрт оёж тогтоосон байна.
- 1.12 Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар
стандартын үзүүлэлтээс давсан илүү сайн чанартай байвал давуу тал болно.
- 1.13 Өвлийн хувцас нь хүснэгтэд үзүүлсэн иж бүрдлүүдээс бүрдэнэ.

№	Эд материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт
1	Өвлийн хүрэм	ш	1	Нийт ажилтнуудад
2	Өвлийн цамц	ш	1	
3	Өвлийн өмд	ш	1	
4	Өвлийн малгай	ш	1	
5	Өвлийн баг	ш	1	
6	Өвлийн бээлий	ш	1	




2. Өвлийн хүрэмний шаардлага:

1	Өнгө	Улбар шар, хар хэх
2	Материал	Гадна материал нь салхи нэвтрүүлдэггүй, амьсгалах чадвартай материал байх
3	Чанар	<ul style="list-style-type: none"> - Ажлын хувцасны чанар нь хэрэглээний болон технологийн тодоройлолтод нийцсэн, монгол хүний хэв шинжит биэийн хэмжээсний дагуу үйлдвэрлэнэ. - Өнгө ба дотор материал нь угаахад агшдаггүй, чийг татаж хөлөргөдөггүй, будаг гардаггүй, дулаан алдахгүй, оёдол даах чанартай байна. - Залгаас бүрийг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийсэн байна. - Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
4	Хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Стандартын шаардлага хангасан байна.
5	Үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Хүрэм нь хүзүүг салхинаас хамгаалахаар урт захтай, захыг хүзүү толгойн хэмжээнээс хамааруулан тохируулдаг кноп эсвэл наалтан тохируулагчтай байна. Захны дотор талын материал хүйтэнд хайрдаггүй, плессэн материалаар хийгдсэн байна. - Хүрэм нь малгай, юүдэнгүй байна. - Хүрэм бүсэлхийн дотор хэсэгт салхи орохоос хамгаалсан, жавар хаасан дулаалгатай байх ба дотор бүсийг биеийн өргөнөөс хамааруулан тохируулдаг байна. - Хүрэмний цахилгаан 2-3 жилийн эдэлгээ даахуйц чанартай байх ба захаас хүрэмний доод ирмэг хүртэл 7 кноптой байна. - Урд талд хормой хэсэгтээ хөндрийрүүлэгчтэй 22x19см хэмжээтэй, тагтай ил халаастай байх ба мөн гар хийхэд чөлөөтэй 12 см-с багагүй, дулаалгатай 2 ташуу халаастай байна. - Зурагт үзүүлсний дагуу станц байршуулахад зориулсан 2 ширхэг гогцоо байна. - Энгэрт бал, жижиг тэмдэглэлийн дэвтэр, утас хийх халаастай 14x9см халаастай, мөн баруун энгэрт цахилгаантай халаастай байна. - Зурагт үзүүлсний дагуу ханцуй, куртканы урд хэсэг хар хөх өнгөтэй байна. - Өвлийн улиралд өмсөх хувцас нь -25С- 35С хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна. - Хүрэмний гадар давхаргын материалын нягт нь 200г/м2-с багагүй, агаар нэвтрүүлэлт 40дм3/м2с"с ихгүй, урагдалтын ачаалал 30Н-с багагүй, суурь утасны тасралт 600Н-с багагүй, угаалгын дараах агшилт, суналт 3,5мг/см2-с багагүй байна. - Дотор давхаргын материалын чийг шингээх чадвар 7,0%-с багагүй байна. - Хувцас үйлдвэрлэлд ашиглах материалууд нь эрүүл ахуйн нормативуудыг хангасан байна. - Салхинаас хамгаалах шаардлагыг хангахын тулд хувцасны давхаргад салхинаас хамгаалах материалан

<p>Үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> - Ханцуйны бугуйн хэсэгт гарыг дааруулахгүйн тулд салхи нэвтрэлтийг багасгах чангалагчтай, дулаалгатай манжет эсвэл сүлжмэл манжеттай байх ба ханцуйг бугуйн бүдүүнээс хамааруулан тохируулах зангуутай байна. - Хүрэм урт загвартай байна. - Зураг №1-д үзүүлсний дагуу гэрэл ойлгогч цацруулагчтай байна. Цацруулагч нь Pantone 17-0000 TPX Frost grey /саарал/ өнгөтэй байна. - Хүйтний улирлын хувцас оёх оёдлын төрөл, ангилал нь MNS ISO 4916:2011, MNS ISO 4675:2012 стандартад нийцсэн байна. - Товчны нүхний урт нь товчныхоо диаметрээс 0,3-0,5см илүү урт байх ёстой. - Халаас, оноо, товчны нүхний ирмэг нь ТЗМ-р бөхлөгдсөн байх ёстой. - Товч хадах, товчны нүхийг гаргахдаа хамгийн багадаа 2 давхарласан материал дээр хийж гүйцэтгэнэ. Товчийг оёхдоо утасны өнгийг товчны өнгө дагуу сонгоно. - Бүтээгдэхүүний материал, утас, туслах материалын өнгөний шийдлийг загварын техникийн бичиг баримтад зааж өгсөн байна. - Бүх ил зах ирмэгүүдийг боловсруулсан байх ёстой боловч сэмэрдэггүй материалтай бүтээгдэхүүнд хийхгүй байж болно. - Гэрэл ойлгогч нь 50мм өргөнтэй, угаахад хуулардаггүй, сайн чанарын ойлгогчоор хийсэн байна. - Компанийн таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. 12x4 см хэмжээтэй байна. - Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 5 см өндөртэй том үсгээр ширж оёсон байна.
<p>6 Загвар</p>	

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
ХЯНАГДАВ
 Ажилтан: *[Signature]*
 2024 он 9 сар 02 өдөр

3. Өвлийн цамцны шаардлага:


1	Өнгө	Улбар шар өнгөтэй, ханцуйны ирмэг, зах, цахилгааны хэсэгт хар хөх өнгийн оруулгатай
2	Материал	Хөнгөн жинтэй, зөөлөн гадаргуутай, дулаан, уян хатан флесе материал байна.
3	Чанар	<ul style="list-style-type: none"> - Ажлын хувцасны чанар нь хэрэглээний болон технологийн тодоройлолтод нийцсэн, монгол хүний хэв шинжит биеийн хэмжээсний дагуу үйлдвэрлэнэ. - Өнгө ба дотор материал нь угаахад агцдаггүй, чийг татаж хөлөргөдөггүй, будаг гардаггүй байна. - 20-25 угаалга даах чадвартай байх.
4	Хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Стандартын шаардлага хангасан байна.
5	Үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Цамцны зах нь 60мм босоо, эргэддэггүй захтай байна. - Биет эвтэйхэн, хөдөлгөөн хорьдоггүй, хөнгөн жинтэй, сунадаг материалтай - Зөөлөн гадаргуутай, амьсгалдаг - Урдаа цахилгаантай - Урд хормойдоо ташуу 2 цахилгаантай халаастай - Ханцуй, хормой хэсэг хар хөх өнгөтэй - Зургат үзүүлсний дагуу цацруулагчтай - Компанийн таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. 12x4 см хэмжээтэй байна. - Байгууллагын нэрийг нурууны хэсэгт 5 см өндөртэй том үсгээр ширж оёсон байна. - Гэрэл ойлгогч нь 50мм өргөнтэй, угаахад хуулардаггүй, сайн чанарын ойлгогчоор хийсэн байна.
6	Загвар	

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
ХЯНАГДАВ
 Ажилтан: *А. Уянга*
 2020 оон 4 сар 12 өдөр


4. Өвлийн өмдний шаардлага:

1	Өнгө	Хар хөх өнгөтэй
2	Материал	55% полиэстр 45% хөвөн даавуу
3	Чанар	<ul style="list-style-type: none"> - Ажлын өмдний чанар нь хэрэглээний болон технологийн тодоройлолтод нийцсэн, монгол хүний хэв шинжит биеийн хэмжээсний дагуу үйлдвэрлэнэ. - 20-25 угаалга даах чадвартай байх.
4	Хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Стандартын шаардлага хангасан байна.
5	Үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Дулаан доторлогоотой - Өмсөхөд эвтэйхэн суналттай ripstop fabric материалтай - Уян хатан, хөдөлгөөнд саад болдоггүй - Өвдөг хэсгээрээ эргономик оруулгатай, хүчитгэсэн материалтай - Өвдөг хэсгээрээ цацруулагчтай - Бүсэлхий хэсгээр агшиж сунадаг - Зурагт үзүүлсний дагуу урдаа 2 ,ардаа 1, 2 гуяндаа халаастай. - Бүсэлхий, тааз хэсгээрээ сунаж агцдаг, тонгойх, шатаар авирах үед оёдол ханзардаггүй, хүчитгэлтэй давхар оёдол хийсэн байх
6	Загвар	

5. Өвлийн малгайны шаардлага:

1	Өнгө	Улбар шар
2	Материал	- 80% ноосон, 20 % полиэстер.
3	Чанар	- Угаахад агшдаггүй будаг гарддаггүй - Оёдол бат бөх - 15 дээш удаагийн угаалт даадаг байх.
4	Хэмжээ	- Стандартын шаардлага хангасан размерууд байна.
5	Үзүүлэлт	- 54-61 см-ийн толгойн тойрогт тохирохуйц байна - Оёдол хөвөрдөггүй
6	Загвар	

6. Өвлийн нүүрний багны шаардлага:


1	Өнгө	Хар хөх
2	Материал	100% даазуу
3	Чанар	- Бөөсөрдөггүй, - цахилгаанждаггүй - Сунадаг материалаар хийгдсэн байх
4	Хэмжээ	- Стандартын шаардлага хангасан размерууд байна.
5	Үзүүлэлт	- 54-61 см-ийн толгойн тойрогт тохирохуйц байна - Оёдол хөвөрдөггүй - Угаалтаар өнгөө алддаггүй - Чих хэсэгт сонсголыг сайжруулахаар давхар торон материалаар өбсөн байх
6	Загвар	<i>Хар хөх</i> 

ӨВЛИЙН АЖЛЫН ХУВЦАСНЫ РАЗМЕРЫН ЗАДАРГАА

Хувцасны иж бүрдэл 3 хос /хэмжээ/	Нийт /тоо ширхэг/
42	10
44	35
46	44
48	118
50	88
52	45
54	18
56	18
58	2
60	2
НИЙТ	380

Үүнд: Өвлийн малгай, өвлийн баг, өвлийн бээлий тус бүр 380 ширхэг байна.

Худалдан авагчийг төлөөлж:


Тавантолгой төмөр зам" ХХК-ийн
Захиргаа, удирдлагын газрын дарга
Я.Намсрай

Худалдагчийг төлөөлж:



Дамэн" ХХК-ийн гэрэнхий нябо
С.Долгодмаа





ДАМЭН ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИ

Монгол улс, Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, 2-р хороо, 69-15 тоот
утас: +976 99326383, 99914653

2022.09.21 № 1/418

танай _____ -ны № _____ -д

Тавантолгой төмөр зам ХХК-д

Үнийн санал хүргүүлэх тухай

Манай компани нь Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн үйлдвэрлэл худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд танай компанид Өвлийн ажлын багц хувцас, хэрэгсэл нийлүүлэхээр үнийн санал хүргүүлж байна.

Техникийн тодорхойлолтод нийцсэн барааг дараах үнийн саналын дагуу хуанлийн 10-25 хоногт нийлүүлэхээр санал болгож байна. Баталгаат хугацаа: 6-12 сар

Нэр төрөл	Тодорх ойлголт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
Хөдөлмөр хамгааллын өвлийн багц хувцас, хэрэгсэл / бхос/	Өвлийн хүрэм	Монгол	380	130,000	49,400,000	4,940,000	54,340,000
	Өвлийн өмд	Монгол	380	65,000	24,700,000	2,470,000	27,170,000
	Өвлийн зузаан цамц	Монгол	380	75,000	28,500,000	2,850,000	31,350,000
	Өвлийн малгай	Хятад	380	27,500	10,450,000	1,045,000	11,495,000
	Өвлийн нүүрний баг	Хятад	380	27,500	10,450,000	1,045,000	11,495,000
	Өвлийн бээлий	Солонгос	380	29,000	11,020,000	1,102,000	12,122,000
Нийт дүн							147,972,000

Үнийн саналын шалгаруулалт болон гэрээ байгуулахтай холбоотой нэмэлт баримт бичиг тодруулгыг нэмэлтээр хүргүүлж болно.

Гүйцэтгэх захирал *Б.Номинзул* /Б.Номинзул/



Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000140198

2005.11.03

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011669034

/ Улсын бүртгэлийн дугаар /

2654296

/ Ревистрийн дугаар /

ДАМЭН

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2000.09.25

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /



4721

/ код /

Гараад худалдаа


Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

1430

4663

Оёдлын үйлдвэрлэл худалдаа

Барилгын материалын худалдаа



/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

39,709.0

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянга-төгрөгөөр /

Улаанбаатар, Сонгинохайрхан, 15-р хороо, өнөр хороолал, 19, 196, Утас1: 96535009, Утас2: , Факс

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяа /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар


/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2017 он 4 сар 10 өдөр

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
ХЯНАГДАВ
Ашигтан:
20 11 4 12 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан тэмдэг
1	Сахьяа овогтой Долгодмав-а Захирал-р томилсныг бүртгэв.	2005.11.03	П.Оюунжаргал
2	Дахин гэрчилгээ олгов.	2017.04.10	С.Мөнхсайчир
1	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2017.04.24	Э.Эрдэнэбилэг
2	Батмөнх овогтой Нямнэл -г Захирал-р томилсныг бүртгэв.	2017.04.24	Э.Эрдэнэбилэг



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
ХЯНАГДАВ
 Ажилтан: *[Signature]*
 2017.04.24 өдөр

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

№	Өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		он, сар, өдөр	Гарын үсэг

Энэ гэрчилгээг хуулбарлах, олшруулахыг хориглоно.

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
 Ажилтан: **ХНГАЛУДАР**
 2013 он сарын өдөр



Нэмэгдсэн өртгийн
 албан татвар төлөгчийн
ГЭРЧИЛГЭЭ №0030244

Үндэсний татварын алба

Татвар төлөгчийн дугаар

2 6 5 4 2 9 6

Нэр: ДАМЭН .ХХК ..

Улсын бүртгэлд бүртгэгдсэн он, сар, өдөр	05.11.03
Үйл ажиллагааны чиглэл	Худалдаа
Байрлалын хаяг утас	Төв аймаг, Зуунмод сум
Удирдлагын овог нэр утас	С.Долзодмаа утас: 88800053
Харилцах банк дансны дугаар	ХААН 5721132341
	Төв аймгийн

Бүртгэж гэрчилгээ олгосон
 Аймаг, нийслэл, дүүргийн татварын алба хэлтсийн дарга

2013 оны сарын өдөр
 Төв аймгийн
 Татварын хурал



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР


БАТЛАМЖ

Дугаар 003460

Дамэн ХХК

/Иргэн, аж ахуйн нэгжийн нэр/

Худалдаа, Үйлчилгээг Зохицуулах Зөвлөлтэй байгуулсан 2020 оны
12 дугаар сарын 20 -ны өдрийн 561 дугаар гэрээг үндэслэн
тус дүүргийн 2 -р хорооны нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл,
үйлчилгээ эрхлэх



Оёдлын үйлдвэр

2654296

Үйл ажиллагааны чиглэл:

Аж ахуйн нэгж, иргэний регистрийн дугаар:

2 дугаар хороо,

Үйл ажиллагаа явуулж буй байршил: 15 тоот

99326383

Холбогдох утасны дугаар:

Цахим хаяг:

ЗХУЧИНГЭЙ ХЭЛТЭС

2022 оны 12 сарын 20 өдөр

20 оны 12 сарын 20 өдөр



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХҮНС, ХУДАЛДАА,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ДАРГА

/Д.СОДНОМДОРЖ/

УЛААНБААТАР ХОТ

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
ХЯНАГДАВ
Ажилтан:
20 20 4 360 өдөр



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: УБД0002105

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Баталгаажуулалтын байгууллагын нэр



Аж ахуйн нэгж, байгууллага/иргэн:


Нэр: ДАМЭН ХХК
Утас/Факс: 99326383
И-мэйл:
Хаяг: БГД ийн 2-р хороо 69- байр 15 тоот

Энэхүү гэрчилгээг олгоход үндэслэсэн баримт, бичгүүд:

1. Сорилтын дүнгийн дугаар, огноо: 745,846-847 2020.10.23
2. Сорилт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн нэр: ШУТИС-ийн Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн сорилтын төвийн итгэмжлэгдсэн лаборатори
3. Удирдлагын тогтолцооны нэр, гэрчилгээний дугаар, олгосон байгууллагын нэр: СХЗГ-ын Баталгаажуулалтын Зөвлөлийн 2021 оны02-р сарын 09-ны өдрийн 01/21 тоот хурлын тэмдэглэл

Бүтээгдэхүүн үйлчилгээний тодорхойлолт:

1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүд ахуй, хамгаалалтын хувцас	6114	MNS ISO 13688:2000
2	Ор хөнгжлийн даавуу	6302	MNS 0330:1986
3	Цэцэрлэгийн хүүхдийн гудас	6302	MNS 6354:2012
4	Ажлын гутал	6403.91.00	MNS 5623:2006



Дээрхи бүтээгдэхүүн үйлчилгээ нь холбогдох стандарт, норматив тогтоомжийн баримт бичиг (НТББ)-ийн шаардлагыг хангаж байгаа тул энэхүү ГЭРЧИЛГЭЭ-г олгов.

В. ГАНЗОРИГ

Гарын үсэг

Д.ВОЛОРМАА

Гарын үсэг



PC 03



2021-02-09

Олгосон огноо
000281

2023-02-09

Дуусах огноо



**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог: Олхонууд	Эцэг (эх)-ийн нэр: Норовсамбуу	Нэр: Удаанжаргал
Албан тушаал: Гүйцэтгэх захирал	Ажиллаж байгаа байгууллага: "Тавантолгой төмөр зам" ХХК	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: ТУЗ-ийн 2018.12.04-ний өдрийн 02 дугаар тогтоол	Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг, "В" блок, 11-р давхар.	
Албан үүргийн төрөл: Гэрээ байгуулах.	Тайлбар: 2022 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн харьцуулалтын дүгнэлтээр шалгарсан "Дамэн" ХХК-тай инжежер техникийн ажилтнуудын "Өвлийн ажлын хувцас /6 хос/" худалдан авах гэрээг байгуулахад ашиг сонирхлын зөрчилгүй болно.	

Сонирхлын зөрчилтэй эсэх

Тийм

Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан _____

би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:


Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

Дөрөв.Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

Гүйцэтгэх захирал:
/албан тушаал/


.....
/гарын үсэг/

Н.Удаанжаргал
/гарын үсгийн тайлал/

2022 он 09 сар 22-ны өдөр

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх Тийм Үгүй

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

- Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй
- Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй
- Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

..... /албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр